



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-19</i>
<hr/>	
<i>1. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>4-19</i>

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 21-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ч.Ундрам;

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл.

Нэг. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын дэд дарга У.Бямбасүрэн, Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын референт Д.Нямдэлгэр, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, “Эрдэнэс Монгол” ХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрэлээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Энхтүвшин, Н.Ганибал нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов. Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 56 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсгийг оруулж ирье. Ажлын хэсэг дуудаадхаарай.

Хэлэлцэх асуудал, нэг. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрх эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулна.

Ингээд сайдын микрофоныг нээе. Ажлын хэсгийн 4 номер.

Д.Амарбаясгалан: *Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ,*

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах Эрдэнэс Тавантолгой компанийг байгуулж, тус компанийн хувьцааны 20 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн билээ.

Өнөөдрийн байдлаар Эрдэнэс Тавантолгой компанийн нийт хувьцааны 18.4 хувийг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн 2.5 сая иргэн эзэмшиж байна аа. Тус компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Засгийн газар өнгөрсөн оны 10 дугаар сард Эрдэнэс Тавантолгой

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр,
Пүрэв Төрийн ордон “Их засаг” танхим
13 цаг 40 минут*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: *Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.*

Дамбын Батлут гишүүн орон нутагт ажиллаж байна. Чинбатын Ундрам гишүүн орон нутагт ажиллаж байна. Ингээд бусад гишүүд хүрэлцэн иржээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал байна. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаарх талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Засгийн газар 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

компанид онцгой дэглэм тогтоож, компанийн үндсэн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, төлбөр тооцоог сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан. Улмаар онцгой дэглэм тогтсоноос хойш компанийн санхүүгийн үзүүлэлт, орлого эрс сайжирч, өр төлбөрийн хэмжээ үнэмлэхүй хэмжээгээр буураад байна. Улсын Их Хурлын 2023 оны 1 дүгээр сарын 8 дугаар тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах, 2021, 2022 онуудад 1072 ширхэг хувьцааны ноогдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ноогдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасан.

Иймд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна аа.

Тогтоолын төсөлд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нийт хувьцааны 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд шинээр эзэмшүүлэхээр, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд компанийн хувьцааг эзэмшүүлж байхаар, өмнө нь компанийн хувьцааг эзэмшиж байгаад зарим хэсгийг эсхүл бүхэлд нь худалдсан суутган тооцуулсан Монгол Улсын иргэд хүсэлт гаргасан тохиолдолд нэрлэсэн үнээр буюу 933 төгрөгөөр буцаан худалдан авах боломжийг олгох, иргэн нас барсан Монгол Улсын

харьяатаас гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байх зэрэг асуудлыг тус тус тусгасан.

Тогтоолын төслийн дагуу 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төрсөн иргэдэд компанийн хувьцааг шинээр эзэмшүүлснээр компанийн нийт хувьцааны 27.6 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмших урьдчилсан тооцоолол гарч байна.

Цаашид компанийн нийт хувьцааны 34 хувьд багтаан 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр төрсөн Монгол Улсын иргэн бүрд хувьцааг эзэмшүүлж байхаар төлөвлөсөн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах үр өгөөжийг иргэндээ хүртээх зарчмыг шинэчлэн тодорхойлж байгалийн баялаг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж хуульчилсан.

Иймд Эрдэнэс Тавантолгой компанийн 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд үе шаттай эзэмшүүлснээр байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүрд тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна аа.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Амарбаясгалан сайдад баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсэг Д.Амарбаясгалан Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх эрхлэх газрын дарга, Ургамлын Бямбасүрэн ЗГХЭГ-ын дэд дарга, Ш.Мөнхцэрэн ЗГХЭГ-ын салбарын Бодлого зохицуулалтын газрын дарга, Ч.Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХК-ийн гүйцэтгэх захирал, Ж.Ганбат Эрдэнэс Тавантолгой ХК дах компани дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Б.Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Ж.Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Б.Гэрлээ Эрдэнэс Монгол ХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Хууль эрх зүйн газрын дарга, Гантулга Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Нямдэлгэр ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт.

Төслийн санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Өнөрболор гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Оруулж ирж байгаа тогтоолын төслийг дэмжиж байна. Энэ бас ингээд олон нийтийг нээлттэй болгох, нээлттэй болгосноороо иргэд хяналтаа тавьдаг тэгээд баялгийн эзэн тэр Үндсэн хуулийн 6.1-д заасан баялгийн эзэд бас өөрснөө баялгаасаа хүртдэг ийм эрх зүйн орчныг бүрдүүлэхгүй бол энэ Эрдэнэс Тавантолгойг тойрсон хулгай бол аймшигтай байна шүү дээ. Энд гадаа яригдаж байна. Энэ Эрдэнэс

Тавантолгойн асуудал хэрэгтэй хэрэггүй баахан улсуудыг л хамруулаад л нэг баахан л юм хийгээд байдаг. Уг нь ярих асуудал маш тодорхой л байгаа шүү дээ.

Тэгтэл тэнд нэг тээвэр хийсэн гээд л жолооч авчирч байцаагаад л тэр нэг тээврийн компанитай тийм холбоотой гээд л ингээд л. Намайг хүртэл холбочихсон явж байгаа юм. Би тэр Шинэжинст Өргөө гэдэг компани мэдэхгүй. Ямар компани байдгийг нь ч мэдэхгүй, миний хүү ч мэдэхгүй. Тэгээд нэг хүний нэр төрд ингээж халдаад л ингээд л яваад байх юм.

Тийм учраас энэ Тавантолгой компанийг нээлттэй болгох нь зүйтэй. Нээлттэй болгох нь зүйтэй. Баялгийн менежментээ зөв хийж байж Монгол Улс хөгжинө шүү дээ.

Бид чинь энэ манай нам засаг барьж байна. Манай намын бодлого чинь нөгөө социал демократ бодлого шүү дээ. Социоль демократ эрх барьж байгаа жинхэнэ шилдэг жишээ тэр. Скандинавын 4 орон, Норттик 5 оронд л явж байгаа шүү дээ. Тэгээд бид чинь нэг юм хөгжил ярихаараа нэг л тийм либерал юм яриад л, үл үзэгдэгч гар яриад л. 300 жилийн өмнө амьдарч байсан хүний хэлсэн үгийг яриад л ингээд яваад байдаг. Энэ бол зөв зүйтэй. Иргэдийн хяналтыг оруулаад ингээд хийх нь зүйтэй гэж ингээж үзэж байгаа юм, нэгдүгээрт.

Энэ дараагийн асуудал юу вэ гэхээр хэд хэдэн асуудлыг би тавья гэж бодож байна.

Нэгдүгээрт нь энэ Улсын Их Хурлын гишүүн Анандбазар нарын 5 гишүүн өнгөрсөн оны 12 сард яг жилийн өмнө энэ Эрдэнэс Тавантолгой компанийн 40 хүртэл хувийг иргэдэд эзэмшүүлье гэдэг ийм хуулийн төсөл

санаачлаад Засгийн газраас санал аваад Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа.

Тэгэхээр энэ өргөн барьчихсан энэ хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн нь өөрөө хууль санаачлах эрхтэй шүү дээ. Тэгэхээр энэ хуулийн төслийг энэ Засгийн газрын орж ирж байгаа энэ саналтай нэгтгээд явах боломж байна уу гэж би 1 дүгээрт асууж байгаа юм^

Хоёрдугаарт бол юу вэ гэхээр энэ 14.8 хувийг иргэд эзэмшиж байгаа. Анхнаасаа энийг хөрөнгийн бирж дээр 14 хувийг нь эзэмшихээж байгаа юм чинь энийг нээлттэй байдлаар ингээд явчихсан бол арай өнөөдрийнх шиг нэг ийм хулгай нүүрлэхгүй байсан юм болов уу гэсэн ийм юм байна. Яагаад нээлттэй болгоогүй ингээд нэг хаалттай явсан юм бэ гэсэн 2 дахь асуулт.

Гурав дахь асуудал бол 933 төгрөгөөр 2028 он хүртэл худалдаж авах юм байна. Энэ зүйтэй энийг бас дэмжиж байна. Тэгэхдээ 2012 оны 913 өнөөдрийн 933 хоёрын чинь хооронд чинь их том зөрөө байгаа шүү дээ. Сүүлийн өөрөөр хэлбэл 2021, 2022, 2023 оны үед энийг хийгдсэн компанийн үнэлгээ гэж юм байдаг юм уу үгүй юу? Энэнтэйгээ хэр зэрэг нийцэж байгаа юм бол? Ийм зүйл байгаа юм. Тэгээд энийг одоо дэмжиж байгаа. Энэ бол энэ баялгийн менежментийг зөв хийх нэг шилдэг жишээ гэж ингэж ойлгож байгаа.

Цаашидаа томоохон компаниудаар ингэж энийг хийж хэрэгжүүлж ингэх ёстой. Манай Монголын хөгжлийн гар чинь баялгийн менежментээ л зөв хийх шүү дээ. Одоо тэр нөгөө бидний яриад байдаг Сингапур Тимосек гээд хэдэн мянгаар очоод үзчихсэн. Сингапурын өөрийн туршилага бол байгаа. Газар зүйн байршлын давуу талаа л ашиглаад л үзчихсэн байгаа шүү дээ. Тэрэн шиг

манайх бол энэ баялгийн менежментээ зөв хийх ёстой юм аа. Тэр утгаараа бол энэ оруулж ирж байгаа энэ төслийг бол дэмжиж байна аа. Асуусан асуултдаа хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүний асуусан асуултад ажлын хэсэг. Хэдэн номер Амарбаясгалан сайд 4 номер хариулъя.

Д.Амарбаясгалан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр оруулж ирж байгаа Засгийн газрын Улсын Их Хурлын тогтоолын төсөл бол үндсэндээ энэ иргэдийн эзэмшиж байгаа Эрдэнэс Тавантолгойн хувьцааг бодитоор нь амь оруулах зорилгыг агуулж орж ирж байгаа юм. Ер нь өмнө нь иргэд хувьцаа эзэмшиж байгаа нэртэй бас нэлээдгүй хэдэн жил буюу үндсэндээ 10 гаран жилийг ардаа орхисон. Харамсалтай нь яг ноогдол ашиг хуваарилагдаагүй гэвэл бас хуваарилагдаж чадалгүй ирсэн. Түрүүн би бас танилцуулга дээр дурдсан байгаа. Тэр нь компанийн эдийн засгийн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор ашиг орлоготой шууд холбоотойгоор асуудалд бол хандаж тайлбарлаж ирсэн байдаг.

Эрдэнэс Тавантолгойн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилготойгоор бүрэн эрхт төлөөлөгчийг томилоод тэгээд Засгийн газар Улсын Их Хурлын түвшинд бүх түвшиндээ анхаарлыг хандуулж ажилласны үр дүнгээр сүүлийн жилүүдэд үр өгөөж бол ихээхэн хэмжээгээр нэмэгдэж бодитой болж гарч ирж байна.

Хоёрт нь Монгол Улсын нүүрсний экспорт бол бас бодитой нэмэгдэж чадлаа. Зөвхөн 2023 онд гэхэд улсын хэмжээнд экспортод гарч байгаа нүүрсний хэмжээ 65 орчим сая тонн болж нэмэгдэж гарч байгаа юм.

Тэгэхээр эдгээр энэ орж ирж байгаа үр өгөөжийг бодитой хувьцааны ноогдол ашиг болгож өгдөг байх энэ зарчим руу орох зорилгыг бол Засгийн газар агуулж байна гэсэн үг. Өмнө нь бол ноогдол ашигт хэдий энэ бага байсан ч гэсэн тэр ноогдол ашигийг хувьцаа эзэмшигчид өгнө гэхээсээ өмнө төр өөрөө шийдвэр гаргаад янз бүрийн төсөл хөтөлбөрүүдэд оруулчихдаг байсан.

Энэ сул талыг бас нэг мөсөн арилгая гэсэн ийм зорилгыг бол агуулж оруулж ирж байгаа. 34 хувь гэж тодотгож оруулж ирсэн шалтгаан маань Монгол Улсад мөрдөгдөж байгаа Компанийн тухай хууль энэ хуульд нийцүүлж цаашидаа энэ компани эдийн засгийн хувьд үр өгөөжтэй тогтвортой үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах түвшний нөхцөл байдал зэрэгтэй бол холбогдуулж бид ийм 34 хувийг иргэдэд шууд эзэмшүүлэх энэ асуудлыг бол тодотгож оруулж ирж байна.

Мэдээж 34 хувийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлэх яг тэр хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хангаж байх гэдэг асуудал дээр бол Засгийн газар энэ Улсын Их Хурлын энэ тогтоолын төсөл дэмжигдээд батлагдсаны үндсэн дээр бол зохион байгуулж хийнэ. Урьдчилсан байдлаар бол нийт хувьцаа эзэмшигчдийн дундаас нээлттэй сонгох байдлаар зохион байгуулдаг эрх нь бүрэн хангагддаг байх тэр нөхцөл рүүгээ явна гэж ингэж бол тооцож байна.

Хоорондоо арилждаг байх гэдэг асуудал бол яригдаад байдаг. Хувьцааг амь оруулна гэдгийг мэдээж хөрөнгийн бирж дээр арилжих боломжоор нь дүгнэдэг. Тэгвэл энэ төрөөс стратегийн ач холбогдол бүхий ордыг эзэмшиж байгаа төрийн өмчит компанийн хувьцааг үнэ төлбөргүй тараах гэдэг анхны концепт гарахдаа арилжихгүй байх зорилгыг агуулсан. Арилжихгүй

байх зорилго бол хэсэг бүлэг хөрөнгө чинээтэй хэсэгт нь энэ хувьцаа төвлөрөхгүй байх нь зөв юм аа. Нийт ард иргэд энэ Үндсэн хуулийнхаа дагуу байгалийн баялгийнхаа үр өгөөжийг тэгш хүртдэг байх нь зөв юм гэдэг энэ агуулга дээр үндэслэгдэж орж ирсэн.

Харин Засгийн газраас энэ удаа оруулж ирж байгаа тогтоол, түүнийг дагаад засгаас гарах тогтоол дээрээ бид юуг агуулж байгаа вэ гэхээр хувьцаа эзэмшигч нь өөрөө төрийн мэдлийн бб хувьтайгаа дотоод бонд хэлбэрээр харилцаа үүсгэх боломжийг бол нээлттэй болгоё гэсэн зорилгыг агуулж байгаа юм. Нэг ёсондоо хувьцаа эзэмшигч ноогдол ашигийг жил бүр тогтмол авдаг байж болно. Эсвэл урт болон дунд, богино хугацаанд энэ бб хувийг эзэмшиж байгаа төр талдаа тодорхой хүүтэйгээр зээлүүлдэг эргээд энэ хувьцаа өөрөө арвижих тэр боломж нөхцөлийг бүрдүүлдэг байх энэ зохицуулалтыг бол бид энэ Улсын Их Хурлын тогтоолыг дагаад гарах Засгийн газрын тогтоол, журмуудад бол нээлттэй зохицуулж өгье өө гэсэн ийм зорилготой явж байгаа гэдгийг тайлбарлая аа.

Ингээд 2 дахь асуултад бүрэн эрхт төлөөлөгч Ганбат дарга хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 6 номер. Ганбат дарга хариулъя.

Ж.Ганбат: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Эрдэнэс Тавантолгой компанийн хөрөнгө бол 19.3 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй гэдэг ийм байдлаар баланс дээр явж байгаа. Бид 2023 оны бас 3 дугаар улирлын байдлаар яах вэ өр төлбөр яг онцгой дэглэм тогтоох үед бол 4.3 их наяд төгрөгийн өр төлбөр байсан. Энийг нэг их наядар

бууруулаад 3 дугаар улирлын байдлаар 3.2 их наядын өр төлбөртэй байна. Энэ урьдчилж олсон орлого гээд өмнө нь нөгөө нүүрсийг борлуулахдаа урьдчилж орлого олдог 603 сая ам.долларын урьдчилж олсон орлого байсан. Энийг сая энэ 2023 оны 9 сарын байдлаар бүрэн барагдуулж дууссан. Бид одоо нийт борлуулж байгаа нүүрсний төлбөрийг 100 хувь авч байгаа гэдэг ийм байдалтай байгаа.

Өмнө нь бол энэ компани дээр бол ямар нэгэн тийм хөрөнгийн үнэлгээ хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж байгаагүй. Бид Улсын Их Хурлаас өгсөн чиглэл, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу олон улсын аудит оруулчихсан. Бид аудит ингээд хийж байна. Бид аудит орсны дараа ер нь энэ компанийг бид бас хөрөнгийн үнэлгээг нь шинэчлэлт хийх ийм асуудал бол тулгарна. Тэгээд хамгийн гол юм бид энэ 34 хувийг олон нийтийн оролцоог бий болгож нээлттэй ил тод болгох гэдэг дээр онцгой анхаарна.

Бид сая онцгой дэглэм тогтоож жил гаруй хугацаанд Эрдэнэс Тавантолгой компани дээр ер нь бүх л үйл ажиллагаанд ил тод болгож байна. Одоо Эрдэнэс Тавантолгой компани дээр ямар нэгэн нууцын зэрэглэлтэй болон нууцад хамаарсан гэрээ тийм байхгүй.

Бид өмнө байгуулагдсан гэрээнүүдийн асуудлыг хугацаа нь дууссангуут нь дуусгавар болгоод байгаа. Ер нь яг уурхай дээрээс олборлолт хийгээд ачигдаад хил гартлах үйл ажиллагаануудыг бүгдийг нь бид ил тод нээлттэй цахим болгох ажилдаа нэлээн онцгой анхаараад ингээд ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн та тодруулж асуух уу?

Тэгвэл Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Монгол Улсын Засгийн газраас оруулж ирж байгаа Эрдэнэс Тавантолгойн хувьцааг Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх 2012 оны 4 сарын 11-ний өдрөөс өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх асуудлыг дэмжиж байна аа.

Одоо Эрдэнэс Тавантолгойн хувьцааны нийт 18.4 хувь нь иргэдийн өмч байж байгаа. 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойших хэдэн хүүхэд байгаа юм бэ? Эрдэнэс Тавантолгойн хэдэн хувийн хувьцаа ноогдох юм бэ? Энэ дээр бас нэг тодорхой бас нэг хариулт хэлж өгөөч.

2 дахь асуудал бол энэ бусад төрийн өмчтэй уул уурхай үйл ажиллагаа эрхэлж явуулж байгаа энэ төрийн өмчтэй компаниудаа ер нь хувьчлах олон нийтийн болгох энэ асуудал дээр ер нь ямар бодлого барьж байгаа юм бэ?

Ялангуяа энэ Хөтлийн цемент шохойн үйлдвэр байж байна. Дарханы Төмөрлөгийн үйлдвэр байж байна гээд. Тэгээд энэ компаниуддаа юу гэдэг юм олон нийтийн болгох хувьцааг нь бас гаргаж худалдах энэ ажлуудыг ер нь хэзээ хийвэл бололцоо боломж гарч ирэх юм бэ? Иргэд маань нэг үеэ бодвол энэ хувьцаа, хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хувьцааг худалдаж аваад эргүүлээд зардаг, ашиг олдог гээд. Энэ төрлийн үйл ажиллагааг нэлээн их сайн мэддэг болчихлоо шүү дээ. Тэгэхээр цаашидаа энэ төрийн өмчтэй компаниудыг л олон нийтийн болгох энэ асуудал дээр л онцгой анхаармаар байна л гэсэн ийм бодолтой байж байна.

Яагаад ингэж хэлээд байна вэ гэхээр л ерөөсөө л энэ төрийн өмчтэй

компаниудын үйл ажиллагааг л энэ Улсын Их Хурлын 76 гишүүнтэй л байнга холбож ярьдаг л боллоо шүү дээ. Сүүлийн 4 жилийн хугацаанд ерөөсөө л ингээд төрийн өмчтэй компани байгаад байх юм бол энэ хулгай зэлгээний асуудал бол ингээд дуусахгүй юм байна.

Тийм учраас эхний ээлжид юу гэдэг юм энэ Хөтлийн цемент шохой үйлдвэрийг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийг Тавантолгойн эдийн засгийн судалгааг нь хийгээд Тавантолгойн компани ч гэсэн олон нийтийн болгох энэ ажил дээр л онцгой анхаарах хэрэгтэй байна. Бид нар юу гэдэг юм арилжааны банкнуудыг тодорхой хувийг бас олон нийтийн болгоод болгочихсон шүү дээ амжилттай болчихсон.

Эсрэгээрээ ингээд төрийн өмчтэй компаниудаа олон нийтийн болгох ажил дээр нэлээн жоохон хойрго яваад байна уу гэсэн ийм бодолтой байж байгаа.

Тэгээд энэ дээр нэг ахиц дэвшил гаргаач ээ. Энэ хулгай зэлгээний асуудлаас 1 дүгээрт салмаар байна. Энэ 76 гишүүн бол бүгд л хулгайч болчихоод яваад байна шүү дээ.

Тэгэхээр энэнээс гарах гарц бол ерөөсөө л энэ. Төрийн өмчтэй энэ уул уурхай эрхэлж байгаа төрийн өмчтэй компаниудаа л олон нийтийн болгох, хувьцааг нь гаргах, иргэд аж ахуйн нэгж байгууллага нь хувьцаагаа хоорондоо худалдан арилжаалдаг ийм хэлбэр рүү л бид нар яаралтай л орохгүй бол нөгөө л нэг төгсдөггүй нэг яриа, дуусдаггүй нэг ярианы л үлгэр болоод л ингээд л яваад байна. Энэ дээр ер нь ямар бодлого барьж байгаа вэ гэдэг энэ асуудлыг асууж байна аа.

Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 4 номер Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Төрийн өмчийн компанийг үе шаттай нээлттэй болгох чиглэлийг бол 2021 онд бас Улсын Их Хурлаас тодорхой нэр бүхий компаниуд дээр гарсан. Түүнээс хойш Монголын хөрөнгийн бирж, Төрийн банк зэрэг байгууллагуудын тодорхой хувийг олон нийтэд биржээр дамжуулж худалдаалах үйл ажиллагаа бас амжилттай зохион байгуулагдсан. Тус тогтоолд бас хэд хэдэн төрийн өмчит компаниуд орсон байдаг юм. Жишээлбэл 21 аймгийн АЗЗА төрийн өмчит үйлдвэрийн газар орсон байх жишээтэй.

Тэгээд яг тэр тогтоолыг хэрэгжүүлээд явахаар жишээ нь аймгийн, орон нутгийн АЗЗА-ийн түвшинд бол нөгөө өөрийн үнэлгээ их багатай, хөрөнгө оруулагч орох сонирхол багатай гэдэг ийм учир шалтгаанууд бол тодорхой түвшинд гарсан байгаа. Ийм учраас Засгийн газраас ямар ажил арга хэмжээг авсан бэ гэхээр ер нь төрийн өмчийн компаниудыг 1 дүгээрт энэ тоог эрс бууруулж цөөлө, үнэлгээг нэмэгдүүлэе, улмаар олон нийтэд нээлттэй болгоё гэдэг энэ бодлогыг барьж ажилласан.

Ингээд бид яг одоо өнгөрсөн жилийн яг өдийгөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд 130 байсан төрийн өмчит үйлдвэрийн газрыг 95 болгож цөөлсөн байгаа юм. Гэхдээ энийг хувьчилсан хэлбэр бол байгаагүй. Татан буулгах, нийлүүлж нэгтгэх ийм ажлыг бол зохион байгуулж байна. Нөгөө талаасаа компанийн засаглалыг сайжруулах алхмыг бол бид авч явж байгаа. Энэ хүрээндээ Эрдэнэс Монгол нэгдлийг албан ёсоор байгуулаад Засгийн газраас дүрмийг нь 3 ч удаа өөрчилж тодотгол хийсэн байгаа.

Урьд нь бол бараг Эрдэнэс Монгол компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хүртэл Засгийн газрын түвшинд авчирч ярьдаг ийм хэлбэр бол байсан. Тэгвэл бидний хийсэн энэ өөрчлөлтөөр олон улсын түвшинд, хөрөнгө оруулалтын түвшинд хамт олон улсын хөрөнгө оруулалтын компаниудтай хүртэл хамтарч ажиллах чадамж бүхий нэгдлийг бий болгож чадсан юм байгаа юм.

Ингэснээрээ Эрдэнэс Монгол компани өөрийн охин одоогийн байдлаар бол 32 компанийн өдөр тутмын үйл ажиллагааг, бодлогыг хяналтыг бүх түвшинд нь тавьж явах чадамжтай болсон. Цаашиаад энэ компани тус бүр дээр засаглалыг нь сайжруулж нээлттэй хувьцаат компаниуд болгох энэ ажлыг бол зохион байгуулна.

Засгийн газар мөн яг энэ хүрээндээ тодорхой төрийн өмчит үйлдвэрийн газруудын үр ашгийг энэ оны эцсээр үр дүнг эцэслэн тооцсоны үндсэн дээр татан буулгах нэгтгэх ажлыг бол үргэлжлүүлж хийнэ гэсэн зорилгыг бол агуулж байна. Бидний төлөвлөгөөгөөр 95 дээр байгаа төрийн өмчит үйлдвэрийн газруудыг цаашидаа 65-д хүргэнэ. 65-д хүрэхдээ түрүүн хэлсэнчлэн ямар нэгэн байдлаар хувьчлалын үйл ажиллагааг бол зохион байгуулахгүй, үйл ажиллагаа, төрөл зүйлээр нь нийлүүлж нэгтгэх чадамжийг нь үнэлгээг нь бодитой болгох чиглэл дээр бол анхааран ажиллана гэж ингэж бол зориод явж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье ээ.

Ц.Цэрэнпунцаг: Тодруулж асуух уу? 2 дахь асуулт байна. Мартагдсан байна. Дахиад Амарбаясгалан сайд гүйцээгээд харуулчихъя. 4 номер.

Д.Амарбаясгалан: 2012 оны 4 сарын 11-нээс хойш үндсэндээ сая гаруй

иргэн шинээр Монгол Улсын иргэн болсон байгаа юм. 2 сая 500 мянган энэ Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааг эзэмшиж байсан бол энэ тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын 3 сая 500 гаруй мянган иргэн бүгдээрээ хувьцаа эзэмшигч болж байгаа юм. Энэ бол Үндсэн хуулийн 6.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж байгаа гэж ингэж ойлгож болно. Нөгөө талаасаа тогтоолын 4 дэх заалт дээр 2024 оны 1 сарын 1-нээс хойш шинээр төрсөн болон Монгол Улсын иргэн харьяатад орсон бол хувьцаа эзэмшигч болох юм гэдэг энэ зүйлийг бол оруулж ирж байна.

Тэгэхээр цаашидаа шинэ юу гэдэг юм энэ 34 хувь дотроо Монгол Улсын нийт иргэд тухайн цаг үедээ хувьцаа эзэмшигч хэлбэрээр явах юм гэж ингэж ойлгож болно.

Ц.Цэрэнпунцаг: Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Энэ хэдүүлээ нэг сонгууль дөхөөд сонгуулийн өмнө бас нэг ард иргэдээсээ санал авах гээд эрх барьж байгаа аль нэг нам нь, нам ч хамаагүй болж дээ тэгээд энэ Эрдэнэс Тавантолгой стратегийн ордууд дээрээ бас төрийн эзэмшлийн асуудал иргэдэд хувьцаа эзэмшүүлэх гээд ингээд нэг асуудлуудыг оруулаад л ирлээ. Тэгээд одоо яг ингээд бодит амьдрал дээр бид нар иргэдийн эзэмшиж байгаа тэр хувьцаа яг баталгаажсаад тэр нь иргэний үндсэн хөрөнгө болж байгаа энэ асуудлууд бол ингээд орхигдоод л яваад байгаа л даа.

Хоёрт нь хувьцаа 1072 хувьцаа эзэмшиж байгаа тэр иргэд өнөөдөр Эрдэнэс Тавантолгойгоос ямар нэгэн хувьцаа авах, түүндээ хяналт тавих ямар ч боломжгүй л байгаа. Тод жишээ нь Эрдэнэс Тавантолгойн ард иргэддээ хувьцаа ноогдол ашиг хувааж өгөх энэ

асуудал бол миний тооцоолсноор шүү зүгээр энгийн математик тооцооллоор 5 жилдээ ямар ч боломжгүй юм байна лээ шүү дээ. Тэр нөгөө оффтейк гэрээнүүд байна.

Төмөр замын оффтейк гэрээнүүдийнхээ нүүрсийг өгөх юм байна лээ. Тэр нефтийн дамжуулах болон оффтейк гэрээнүүдийн нүүрсээ өгнө, тэр угаах нүүрс боловсруулах тэр үйлдвэрийнхээ гэрээний мөнгийг төлнө гээд. Тэгээд ийм боломжгүй юман дээр хэдүүлээ ингээд ард иргэдээ хуураад нийтэд нээлттэй мэдээллээ өгдөггүй. Тэгээд зээл авч байгаад ч хамаагүй төлөх гээд байгаа юм уу эсвэл, хувьцаа өгөх гээд байгаа юм уу нэг иймэрхүү л асуудлыг л хийх байх л даа. Зүгээр боломжгүй юм гэдэг маань өөрсдөд байгаа бүх боломжоо шавхаад урьдчилаад тооцоо хийчихсэн юман дээр бид нар араас нь энэ асуудлыг ярих нь өөрөө бас ёс суртахууны хувьд жосоохон утгагүй асуудал юм. Энэ чинь бас нэг засаглал, компанийн засаглал байна. Тэгээд дээрээс нь энэ дээр бид нар бас яг мэдээлэлтэй байгаа. Эрх мэдэлтэй байгаа төрийн өмчит компанийн маань яг энэ бодит мэдээллүүдийг бас ард иргэддээ бодитоор нь өгч байх ёстой байх гэж бодож байна. Яах вэ зүгээр ер нь заавал 34 хувь гээд 34 хувь бол бас яг компанийн засаглал дээр бол ард иргэд бол энэ олон хувьцаа эзэмшигч нар 3 сая Монголчууд өнөөдөр энэ дээр 34 хувь дээр хяналт тавихад боломжгүй ээ. Энийгээ 40 хувь болгоё. Эсвэл 49 хувь болго.

Өнөөдөр Эрдэнэс жижиг Тавантолгой бол 49 байдаг. Тэрэн дээрээ хяналтаа сайн тавьж чаддаг. Тэгээд хамгийн гол нь хувьцаа эзэмшиж байгаа иргэд болгон аж ахуйн нэгж болгон жил болгон ноогдол ашгаа авч чаддаг байхгүй юу. Тэгэхээр бид нар авч чаддаг тэр тоо хэмжээнд нь тултал аваачиж энэ 49 юм уу, 40 хувь болтол нь энэ

асуудлуудаа л 40-өөс 49 хувь болгох л зайлшгүй шаардлага байгаа юм аа. Энэ хувийг иргэдэд очих хувийг. Ингээж явбал бас болж байна аа.

Дараа нь болохоороо энэ асуудал дээр Ардчилсан намын бүлгийн гишүүн Адышаа гишүүн энэ асуудлыг өргөн бариад асуудлаа энэ Эдийн засгийн байнгын хороон дээр саяхан 14 хоногийн өмнө билүү хэлчихсэн. Тэгээд харамсалтай нь тэр үед бол манай Байнгын хороон дарга бол ер нь жосоохон дэмжихгүй байдалтай байсан. Тэгээд өнөөдөр бол Засгийн газар нь өргөн барингуут шууд ингээд ээлжит бус хуваарийн бус хуралдааныг хийгээд энэ асуудлаа ярьж байна шүү дээ тийм үү?

Дараа дараа зөв зөв асуудлууд хэний бүлгийн хэн нь тавих нь хамаагүй шүү дээ. Ингээд хэлэлцдэг байгаасай дарга аа.

Тэрнээс одоо юу гэдэг юм нэг намын даалгавраар асуудлуудаа ингээд яриад, тэгээд бусдыгаа ч, Их Хурлын гишүүдийг ч хүртэл ингээд чирэгдүүлээд баймааргүй байна аа. Тэгээд миний үндсэн санал тэр 34 хувийг 40-өөс 49 хувь болгомоор байна гэдэг дээр та бүхний саналыг сонсьё.

Ц.Цэрэнпунцаг: Ганибал гишүүн гол нь асуулт биш санал хэллээ. Ийм боломж байна уу гэж байна тэр. 49 хүртэл энэ оролцоо иргэдэд олгож байгаа хувьцаагаа нэмэх боломж байна уу, үгүй юү, энэний судалгаа хийсэн юм уу үгүй юү гэдэг дээр хариулъя. Ажлын хэсэг 4 номер Амарбаясгалан сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Ганибал гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын 2023 оны 1 дүгээр сарын 08 дугаартай тогтоол батлагдаж Засгийн газарт үүрэг

өгөгдсөн. Эдийн засгийн байнгын хорооноос бас энэ тогтоол батлагдаж байсан. Тухайн тогтоолын агуулга нь өөрөө иргэн бүр хувьцаа эзэмшигч байх ёстой энэ асуудлыг судалж оруулж ирж шийдвэрлүүл гэсэн үүргийг Засгийн газарт өгсний дагуу өнөөдөр Засгийн газар оруулж ирж байгаа. Бид өнөөдөр энд ноогдол ашиг тараах талаар тогтоолын төсөл бол оруулж ирээгүй байгаа. Иргэн бүр хувьцаа эзэмшигч болъё гэдэг энэ асуудлыг хөндөж байна. Тэр дундаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Компанийн тухай хуулиар хяналтын багцыг буюу 34 хувийг ард иргэд хувьцаа эзэмшигчийн хувиар хүртэх нь зүйтэй юм гэж ингэж үзэж байгаа. Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд эдийн засгийн үр өгөөж ихээхэн хэмжээнд нэмэгдэж байгаа. Ялангуяа 2022, 2023 онд бол урьд урьдын жилүүдтэй харьцуулахад хэд дахин гэж үржигдэхүйц хэмжээнд үр ашигтай ажиллаж чадаж байгаа. Энэ бол нүүрсний экспорт өөрөө нэмэгдсэнтэй холбогдож байна. Засаглал, үйл ажиллагаа тогтворжиж бас сайжирч байгаа үр дүн гарч байна. Яг энэ хүрээнд жишээ нь Эрдэнэс Тавантолгой мөн Эрдэнэс Монгол нэгдэл бол яг Төлөөлөн удирдах зөвлөл буюу засаглалынхаа түвшинд 49 хувийгаа хараат бус хяналтын тэр түвшинд авааччихсан. Төрийг төлөөлж байгаа нь бол 51 хувь дээрээ хүрчихсэн. Ямар нэгэн байдлаар өдөр тутмын улс төрийн нөлөөлөл үзүүлэхгүй байх тэр бүх нөхцөл байдлын төлөө бид бол ажиллаж байгаа.

Засгийн газрын энэ тогтоол өргөн барьсан. Энэ тогтоолын төсөл бол цаашидаа энэ хувьцаа эзэмшигчдийн өмнөөс төр өөрөө шийдвэр гаргаж янз бүрийн төслүүдэд хөрөнгө оруулалтыг шууд хийдэг байдлыг үндсэндээ зогсоож байгаа юм.

Энэ хувьцаа эзэмшигчээс зөвшөөрөл авсны үндсэн дээр тэдний

эзэмшиж байгаа хувьцаанд ноогдож байгаа ноогдол ашгийг тодорхой арилжааны зориулалтаар авч тодорхой хугацааны хүүтэйгээр зээлж авч хөрөнгө оруулалтад хийх боломж нөхцөлөө нээлттэй болгох зэрэг алхмуудыг хийхийн төлөө оруулж ирж байгаа юм.

Хэрвээ иргэн мэдээж хүсвэл ноогдол ашигаа шууд хүртэж авдаг. Хэрвээ хүсвэл дунд болон урт хугацаанд энэ 66 хувийн талын эзэмшигч төр одоо хүүтэйгээр зээлдэг байх тэр харилцааг бодитой болгох гэж оруулж ирж байгаа юм. Тэгээд 1 талаасаа харахаар хөрөнгийн бирж дээр арилждаггүй амьгүй хувьцаа гэж нэрлэгдэж байгаа боловч нөгөө талдаа компанийнхаа засаглалын хувьд дотоод менежмент зохион байгуулалтынхаа хүрээнд энэ бүх зүйлийг бодитой болгож амь оруулах боломжтой гэж бидний зүгээс үзэж оруулж ирсэн юм аа.

Ц.Цэрэнпунцаг: Ганибал гишүүн хариулт хангалттай юу?

Тэгвэл ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүн үгээ хэлье.

Б.Баттөмөр: Манай гишүүд энд орж ирж байгаа. Энэ тогтоолын төслийг дэмжиж байна. Би ч гэсэн дэмжиж байгаа. Иргэдэд иргэдэд ер нь баялгийн өгөөжийг хүртэх ёстой. Монгол Улс чинь дэлхийд баялгаараа эхний есөд орж байгаа шүү дээ. Гэтэл бол нөгөө албан ёсны 28 хувийн ядуурлаар тооцохоор 904 мянган хүн ядуу амьдралтай эдийн засгийн эрх чөлөөгүй байгаа.

Дээрээс нь ядуурах магадлалтай 15 хувь гээд үзэхээр бас 400. Энийг дахиад би хэлж байгаа шүү. Тэгээд ийм есөд ордог ийм баялагтай мөртөө ийм ядуу байна гэдэг бол үнэхээр харамсалтай байгаа байхгүй юу. Тэгэхээр баялгийн менежмент гэдэг юмыг би байнга ярьдаг. Тэгээд л ажил болохгүй л яваад байгаа юм л даа. Яах вэ энэ түрүүчээсээ ингээд ажил болж байгаад бас сайн байна.

Монгол Улс өөрөө худалдааны эдийн засагтай шүү дээ тийм нүүрс дээр суурилсан эдийн засагтай Худалдааны эдийн засаг Худалдааны хууль байхгүй. Санаачилсан тэгээд хүмүүс дэмжиж энийгээ хийдэггүй. Ийм замбараагүй л яваад байх л ийм сонирхол байдаг юм уу яадаг ч юм. Одоо энэ дээр нэг ганц жишээ хэлье л дээ. Хятад улс дэлхийн хамгийн том нүүрсний импортын хэрэглэгч, гаднаас авдаг. Монгол Улсын экспортолж байгаа кокосжих нүүрс ОХУ-ын кокосжих нүүрснээс 18 хувиар бага.

Дэлхийн түвшинд гээд ингээд тэр Австрали гээд бусад газруудынхтай үзэх юм бол 50 хувиар бага байгаа юм. Дэлхийн банк ингээд хэлчихсэн юм. Миний тоо биш шүү. Ийм байх юм.

Тийм учраас бол энэ баялгаа үнэ хүргэж худалдах энэний баялгийн өгөөжийг ард түмэнд хүртээх нь бол зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм байна аа. Манайхан бол ингээд сүүлийн үед яаж байх юм. Төрийн өмч л их муухай. Төрийн өмч байгаад л ингээд л хулгай гараад л байна гэж. Төрийн өмчдөө биш шүү дээ. Төрийн өмчтэй Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой 2 Монголыг тэжээж байгаа шүү дээ. Тэр компанийн засаглалд нь байгаа юм. Тэнд очсон хүмүүс байгаа юм. Ажиллуулж байгаа хүмүүст нь байгаа болохоос биш төрийн өмчдөө буруу байхгүй шүү дээ. Бид нарын нөгөө дагаж дуурайдаг бид

явах гээд байгаа тэр Скандинавын орнууд чинь энийг чинь хийчихсэн байж байгаа шүү дээ.

Дэлхийн хамгийн аз жаргалтай хүмүүс тэнд амьдарч байгаа. Тийм учраас бол энэ засаглалд нь тэр боловсон хүчний шилжж сонгох энэ юманд нь учир байгаа болохоос биш тэр төрийн өмчтэй биш шүү. Тухайлбал энэ Сангийн яамны ТНБД энэ Ганбат сая БЭТ гээд нэг хэдэн сар нэг жил ажиллав уу? Энэ хүний хувьд бол үнэхээр их тодорхой том дэвшил гарсан шүү. Хулгайнуудыг цэгцэлсэн, түрүүлээд авчихсан өрийг төлсөн. Бас нэлээн олон дайсантай л болох шиг боллоо л доо. Үнэн үг хэлсэн ажил хийх гэсэн хүн Монголд дайсан болдог л ийм л байгаа шүү дээ.

Тийм учраас бол юу вэ гэхээр Ганбат бол харуулсан. Тэгээд энэ ажлыг бол ингээд цаашаа сайн авч явах ёстой гэж ингэж үзэж байгаа. Манай эдийн засгийн өсөлт 6.3 хувь гэж байгаа юм. Энэний чинь бараг 3.5, 3.6 хувь нь энэ нүүрснээс үүссэн ид өсөлт байгаа шүү дээ.

2.1 хувь нь энэ тээвэртэй холбоотой өсөлт. Цаад талд нь нэг хувь нь үйлчилгээний өсөлт гэж байгаа юм. Ийм л 3 бүтэц л байж байгаа байхгүй юу. Манай өсөлтийн. Тийм учраас бол юу гэхээр зэрэг энэ баялаг дээрээ менежмент хийх нь ядуурлаас гарах ард түмнээ энэ ядуурлаас гаргах ард түмнийхээ амьдралыг өөд нь татах гол энэ эх сурвалж нь энд байна шүү гэж. ингэж байж байгаа. Төрийн өмчтэй компаниуд л гэж байгаа юм. Бид нар тэр төсвөөс үр ашиггүй нь энд туначихсан л байгаа шүү дээ. Эрдэнэт, Тавантолгой гээд нэг 2, 3 компани л байгаа шүү дээ. Үр ашиггүйг нь хүн хувийнх нь аваагүй учраас тунаад үлдчихсэн байхгүй юу.

Тэгээд тэр үр ашиггүйг аваад энэ цэвэрлэх байгууламжийг дулааныг, цэвэр усыг аваад явах хувийн компани байвал өгөх хэрэгтэй шүү дээ. Өнөөдрийн энэ түвшинд нь үнээ бариад. Ард түмнээ орлогожуулах хэрэгтэй юм байна. Энэ яг ингээд үзэхээр зэрэг ерөөсөө энэ манай энэ нүүрсний уурхайнууд бүгд алдагдалтай. Үйлдвэрлэж байгаа тэр өртгөөсөө бага үнээр худалдаж байна шүү дээ. Энэ юутай холбоотой вэ гэхээр иргэдийн орлого байхгүй. Ийм л юм харагдаад байгаа юм л даа. Тэгээд энийг та бүгд үзнэ биз дээ.

Тэгээд энэ сая ингээд гарсан бас нэг судалгаагаар Монголд хамгийн их мөнгө юу орж ирж байна гэхээр нүүрс. Энэ дотроос яах вэ голлох нь манай Эрдэнэс Тавантолгой 7.1 тэрбум доллар оруулаад ирсэн дээр нь юу гэхлээр зэрэг Эрдэнэтийн зэс 2.2 тэрбум доллар. Сая одоо нэг гайгүй энэ манай аялал жуулчлал 7.1 тэрбум доллар, Эрдэнэтийн зэс 2.2 тэрбум доллар тэгээд аялал жуулчлал 1 тэрбум доллар, алт бол нэг 676.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн үгээ хэлье.

М.Оюунчимэг: Иргэн бүрдээ хувьцаа эзэмшүүлэх асуудлыг оруулж ирж байгааг 100 хувь дэмжиж байна. Энэ бол маш чухал. Сая бас Баттөмөр гишүүн хэлж байна л даа. Уурхай бүхэн Монголд алдагдалтай ажиллаж байна гээд. Эрдэнэс Тавантолгой тэр дотор алдагдалтай байгаа учраас иргэдийнхээ 2020, 2021, 2022, 2023 оны ноогдол ашгаа одоохондоо өгч чадахгүй өгөх асуудлыг тооцоо судалгаа хийж байгаагаа хэлж байгаа. Энэ бас аргагүй юм байна шүү дээ?

Нүүрсний сонсголыг харж байхад нүүрсний хулгай бол нээрээ дээд түвшиндээ бол замбараагаа алдчихсан

байна л даа. Арай дэндчихсэн алдагдалтай ажиллахаас ч аргагүй. Огт хэрэггүй, шаардлагагүй төслүүдэд Эрдэнэс Тавантолгойгоос санхүүжилт баахан хийчихсэн хамгийн сүүлийн бодит жишээ Богд төмөр зам гээд ярьж байна л даа. Богд хаан төмөр зам гээд одоогийн байдлаар 113 тэрбум төгрөгийг зүгээр эхний ТЭЗҮ гэж гаргаад ашиггүй боллоо гээд. Тэгээд л ТЭЗҮ нь өөрөө тэрбум, тэрбум ам.доллороор хэмжигдчихсэн. Тэгээд ажил нь огт хөдлөөгүй ноль. Тэгээд л ямар ч шаардлагагүй юмнууд дээр Эрдэнэс Тавантолгойг 66 хувь эзэмшинэ гээд л мөнгө гаргаад л байдаг Эрдэнэс Тавантолгойгоор. 70 хувь нь мөнгөөрөө, 30 орчим хувь нь нүүрсээр гэдэг. Тэгээд эргээд аль нь ч төлдөггүй.

Одоо жишээ нь энэ Богд хаан төмөр зам ажил нь 0 байгаа хэрнээ асар их мөнгө Эрдэнэс Тавантолгойгоос ТЭЗШ гэх мэтээр гарчихсан хэрнээ буцааж төлөх ямар ч юу байхгүй. Яагаад гэвэл улсын нууцад хамрагдсан ч гэдэг юм уу. Тэгэхээр одоо нээрээ үнэхээр энэ Эрдэнэс Тавантолгойгоо ашигтай болгохын тулд ингэж хувьцаа эзэмших ер нь зах зээлийн жамаар явахгүй бол Эрдэнэтийгийн 49 хувийг бид Оросоос авч байхад байсан үнээс 7 дахин их хүнийг жишээ нь ганцхан Богд хаан төмөр зам руу голомт руу мөнгө урсгаад оруулчихсан зүйлүүд энэ тэр байж байна шүү дээ.

Энэ бол зүгээр л хулгай л явж байна. Ийм байгаад байхад бид иргэд зөвхөн иргэдийнхээ энэ 1072 ширхэг хувьцааныхаа ашгийг өгч чадахгүй өр төлбөртэй гэсэн хэрнээ тэр дээрээ болсон чинь ингээд бүүр тэрбум тэрбум доллороор нь Эрдэнэс Тавантолгойн буюу нүүрсний хулгай үнэндээ гаарсан байна шүү дээ.

ДЦС 2-ыг барьчих, Улаанбаатар хотын энэ эрчим хүчний бололцоог

бүгдийг нь хангачих мөнгө нүүрсний хулгай жишээлбэл 2013 оноос хойш явсан байна л даа. Энэ крантыг л хаахгүй бол бид нар өнөөдөр хэчнээн 34 хувийг иргэн бүртэй тэгш хуваарилах 1072-оо ашигтай ажиллуулаад иргэддээ ашигийг нь хүртээх энэ асуудлууд цаашидаа ч асуудал асуултын тэмдэг хэвээрээ байна. Тийм ч учраас бид нар энэ Засгийн газар ч гэсэн энэ хулгай дээрэмтэйгээ маш сайн тэмцэж байгаа.

Бид нар Их Хурал дээр ч гэсэн сая нээлттэй сонсгол хийж байна. Эндээс олон нийт олж харж байна л даа. Хаана алдаа байгаад байгаа юм бэ гээд. Одоо энэ асуудлыг бид ингээд цэгцэлж арга хэмжээ авах хүмүүст нь арга хэмжээ авч тэр эргээж Эрдэнэс Тавантолгойгоос мөнгө аваад нэг ширхэг ч хүрз хөдөлгөөгүй юм уу, ажил хийгээгүй. Эсвэл тэр нь яг гүйцэтгэлийн дагуу хийгдээгүй юмнуудыг буцааж төлүүлэх асуудал дээр ч гэсэн манай Засгийн газар маань Эрдэнэс Тавантолгойн ТУЗ энэ тэр анхаарах хэрэгтэй байна л даа.

Тэгвэл асар их мөнгө буцаж орж ирнэ. Гэтэл өнөөдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам гээд яг энэ асуудлуудаар нь хяналт тавиад өөрсдөө ТЭЗҮ-ээ боловсруулаад ингэж хийхийн оронд асар их ТЭЗҮ нэрийн дор ингээд л өнөөдөр Эрдэнэс Тавантолгойгоос жишээлбэл нөгөө нүүрс малгайн дор их мөнгө ингээд л хууль бус хуйвалдааны замаар яваад алга болчихоод байна. Тэгээд иймэрхүү зүйл дээрээ бид нар энэ үнэхээр цэг тавих цаг болжээ. Тэгэхгүй бол иргэд энэ ядуурал буурахгүй байна.

Ажилгүйдэл ямар байна бас том том асуудлуудаа би шийдэж чадахгүй байгаа шүү дээ. Яагаад гэвэл энэ асар их мөнгө шаардлагатай. Ийм учраас би энэ Эрдэнэс Тавантолгойн ТУЗ-ийг энэ

асуудлууддаа жоохон хариуцлагатай байгаад иргэдийнхээ 1072 хувьцааг бас он гараад энэ 2021, 2022 онуудтай нь хамт оногдуулах тал дээрээ санаачилгатай сайн ажиллаач гэж бас хэлмээр байна аа. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Пүрэвдорж гишүүн үгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Хөгжлийн банк, нүүрс, нүүрсний хулгай, төмөр замын хулгай гээд олон хулгайнууд гарсан. Тэгээд энэ дээр одоо яадаг вэ гэхээр хэн нэгэн Их Хурлын гишүүн хэн нэгэн сайд нарын цүнх барьдаг нөхдүүд тэнд очиж тонон дээрэмддэг ийм зүйл. Маш их байсан учраас маш их хулгай гарч байгаа. Тэгээд эндээс нэг гарах гол үндсэн өнөөдрийг хүртэл яах вэ дээ энэ нэлээн олон хэлсэн л дээ энэ хулгайнаас яаж гарах вэ гэдэг асуудлыг тавиад байгаа юм.

Эндээс гарах үндсэн арга бол компанийн засаглалыг сайжруулах. Өөрөөр хэлбэл Компанийн тухай хуулиар 34-өөс дээш тэр төлөөлөн удирдах зөвлөлөөрөө дамжуулаад гүйцэтгэх удирдлагад иргэд хүнээ томилох цүнхчин нөхөр тэнд очих боломжгүй болох л ийм л гол зүйл байгаа. Тэгээд энэ хүрээндээ би 7 сарын 1-нд Эрдэнэт үйлдвэрийн 20 хувийг ард иргэдэд үнэгүй эзэмшүүлэх 20 хувийг нь НДШ төлдөг ажилтан албан хаагчдаа үндэсний компаниудад тодорхой үнээр борлуулж эзэмшүүлэх ийм тогтоолын төслийг өргөн барьсан.

Энэ бол энэ компанийн засаглалд ялангуяа төрийн өмчийн компаниудад илүү ард иргэдийн хяналт компаниудын хяналтыг оруулснаар илүү үр дүнтэй ажиллах ийм боломжийг гаргана гэж үзэж байгаа.

Тийм учраас өнөөдрийн энэ оруулж ирж байгаа 34 хувийн энэ Эрдэнэс Тавантолгойн 34 хувийг иргэдэд эзэмшүүлэх энэ заалтыг дэмжиж байна. Тэгэхдээ МАН сонгуульд ялахын тулд юу ч хамаагүй үнээр ялах ийм зорилгыг агуулж байгаа. Эрдэнэс Тавантолгой энэ оны эцсээр ойролцоогоор 3 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Энэ 3 их наяд төгрөгөөс 1 их наяд төгрөгийг нь компанийн хуучин өр дарахад зарцуулна. Заримыг нь шинэ хөрөнгө оруулалт энэ тэрд 1 их наядыг нь авч үлдэнэ. 2 их наядыг нь 3 сая 400 мянган гэрээн дээ 4 сарын сүүл 5 сарын эх хавиар тарааж өгнө.

580 мянган төгрөг нэг иргэнд очно. Энүүгээрээ санал худалдаж авах хэрэгсэл болгох гэж байгаа. Болгох гэж байна. Ер нь МАН эрх баригч нар олон талаар сонгуульд ялахын төлөө зүтгэж байгаа. Өөрөөр хэлбэл улсын 2024 оны улсын төсөв бол яг бүсчилсэн тэр хөрөнгө оруулалтуудыг маш их тавьсан. Өөрөөр хэлбэл Говь-Алтайг Завхантай, Ховдыг устай, Өвөрхангай, Булган гээд. Дээрээс нь одоо Өмнөговь, Дундговь тэгээд цаашаа эргээд Сүхбаатарыг Дорнодтой тэгээд Хэнтийгийн цаашаа тамын замуудыг бүрэн шинэчлэх энэ тэр зэргээр ер нь бол бүсчилсэн тийм хөрөнгө оруулалтуудыг маш их тавьж энэ сонгуулийн төсөв болгосон байна лээ.

Яг өнөөдрийн энэ хууль бүсчилсэн тойргийн сонгуулийн хууль орж ирэхэд би тэрийг л би мэдэрч байгаа. Тэгээд ард түмний төлсөн хөрөнгө мөнгө дээрээс нь ард түмэнд 1072-оор очих ёстой тэр хувьцааны мөнгө өчнөөн олон жил очоогүй байж байж сонгуулийн өмнөх 4 сар 5 сард очих нь. Энэ бол одоо хэдийгээр дэмжиж байгаа боловч тийм яах вэ дээ тэгээд ард түмэн сонголтоо хийх л байх л даа. Эрх баригч нар хүссэн хүсээгүй тэр хөрөнгө мөнгийг тэр

хувьцааг тарааж өгөх байх. Ард түмэн ухаантай даа.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд үг хэлж дууслаа.

Би нэг товчхон бас үг хэлчихье. Энэ орж ирж байгаа Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа. Хамгийн гол нь энэ тогтоолын төслийн гол ач холбогдол бол өнөөдөр энэ сая гаран хүүхэд одоо 2014 оноос хойш төрсөн хүүхдүүд хийгээд энэ хувьцаа эзэмшигч болгож эд хөрөнгөтэй болгож байгаа нь бол өндөр ач холбогдолтой. Одоо бид нар энэ өнгөрсөн 2, 3 жил энийг олон гишүүд бас ярьж байсан. Энэ хүүхдүүд хийгээд хоцрогдоод байна. Энэ хүүхдүүдийн энэ хувьцаа эзэмших асуудлыг нь яаж шийдэх вэ гээд. Энийг өнөөдөр оруулж ирж байгааг бид нар дэмжиж, Байнгын хорооноос бол энийг өнөөдрийн энэ тогтоолын төсөл дээр дэмжиж байна. Тэгэхдээ ажлын хэсэг гаргаж энэ дээр бас нухацтай ажиллах хэрэгтэй. Энэ дээр нэг анхаарах 2 асуудал байгаа юм.

Өнөөдөр компанийн эзэн байх, хувьцаа эзэмшигч эзэн. Тийм энэ эзэн байхад одоо энэ бид нар анхаарах нэг зүйл бро эзэн юм бол эзэн чинь энэ хувьцаагаа арилжаалах юм уу эсвэл бусдаас хувьцаа нэмж авах юм уу, мөн ноогдол ашгаа авах эсэхээ компани дээрээ хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд оролцож саналаа хураалгаж ингээд энэ компанийнхаа үйл ажиллагаанд ингэж идэвхтэй нээлттэй оролцож байж энэ нээлттэй компани болно оо.

Өнөөдөр мэдээж бид томилогдоод олон ажил хийсэн, нээлттэй болгосон. Тэгэхдээ энэ л хангалттай биш. Энэ бол зөвхөн компанийн хийсэн гэрээ хэлэлцээр хөрөнгө оруулалт яаж хийгдсэн юм, яаж үйл ажиллагааны зардлаа гаргаж байгаа юм гэдгийг нээлттэй болгосон нь

бол нэг хагас нь, нөгөө хагас нь бол өнөөдөр энэ компани 100 хувь нээлттэй ил тод байхад бол энэ компанийн хувьцаа эзэмшигчид нь энэ компанийнхаа өнөөдөр хөрөнгө оруулалт хийх юм уу, эсвэл хувьцаа хэлбэр хувьцааны ашиг хэлбэрээр тараах юм уу энэ жилийн ашиг орлогоо. Энийгээ энэ шийдэхэд санал өгч оролцдог байж байж энэ компанийн жинхэнэ эзэн болно.

Тийм учраас энэ дээр бас ажлын хэсэг дээр цөмөөрөө гүнзгийрүүлж ажиллая. Дээрээс нь ажлын хэсэгт бол мэдээж манай Санхүүгийн зохицуулах хорооныхон байгаа. Энэ нөгөө энэ хувьцаа үнэт цаасны талаар мэргэшсэн залуучууд байна. Энэ компанийн эрх зүйн талаар бол мэдлэгтэй, бас нэлээн гүнзгий, гайгүй сайн ойлголттой бас энэний мэргэжилтэн байгаа.

Тэгэхээр энэ бүх ажлын хэсэгт орж ажиллах хэрэгтэй. Хамгийн гол нь энэ хувьцаа эзэмшигчид чинь энэ хувьцаагаа эзэмшээд дараа нь энэ иргэн нас барсан тохиолдолд энэ хувьцаа нь автоматаар буцаад энэ төрийн эзэмшилдээ үлдэх нэг ийм агуулга яваад байгааг бас анхаармаар байгаа юм. Энэ нь яагаад гэвэл бид нар анхаарах ёстой нэг 2 зүйл бол энэ өнөөдрийн бид нар зах зээлийн нийгэм, энэ ардчилсан нийгэмд амьдарч байгаагийн 2 одоо нүдний цөцгий мэт хайрлах ёстой 2 зүйл бол хүний эрх, хувийн өмч хоёр.

Тэгэхээр бид нар ард түмэндээ энэ үндэсний том компанийнхаа хувьцааг ингээд өмч нь болгоод өгч байгаа юм бол нас барангуут нь тэр нь автоматаар буцаад төрийн өмч болчихдог. Энэ зарчим нь тэр компанийнхаа хуультай одоо иргэнийхээ хууль эд нартай зөрчилдөж байгаа эсэх дээр бид нар сайн анхаарч ажиллах ёстой.

Дээрээс нь бид нар өнөөдрийн энэ тогтоол гарч байгаа бас нэг зүйл бол энэ төрийн өмчтэй компаниуд дээр гарсан энэ асуудлууд бид нар энд анхаарал хандуулах ёстой. Энийг засаж залруулах чиглэл рүү ажил хийх ёстой. Энэнтэй л оруулж ирж байгаа учраас бас цаг үе нь бас, энэ цаг үед л ийм шийдвэр гаргаж байгаад Засгийн газарт ийм санал оруулж ирж байгаад талархаж байна.

Дээрээс нь компанийн хамгийн гол асуудал бол өнөөдөр энэ ер нь зүгээр энэ асуудал хамгийн гол өнөөдөр гарч байгаа асуудал бол төрийн өмч, Төр ард түмнээ төлөөлөөд энэ компаниудаа хувьцааг нь эзэмшдэг байж болно төлөөлдөг байж болно. Хамгийн гол нь энэний удирдлагыг бид нар энэ эзэмшигчээс нь салгах ёстой. Энэ компанийн хуулийн үндсэн агуулга бол энэ.

Тэгэхлээр компанийн хуулиараа бид нар өнөөдөр төр хамгийн гол нь эзэмшигчээд ард түмнээ төлөөлөөд энэ компанийн эзэн болж хувьцааг нь эзэмшиж суучхаад дээрээс нь менежментийг нь шууд томилж оролцож байгаа нь л энэ компанийнхаа хуулийг зөрчөөд байгаа шүү дээ. Энэ дээр бид нар бас анхаарч энэ алдаа дутагдлыг бас засчих залруулчих, энэ дээр дахиад нэг алхам зөв тал руу нь хийчих юм уу ямар боломжууд байна ингээж ажиллая гэснээрээ анхаарч ажиллая гэж бодож байна.

Ингээд цөмөөрөө санал хураалтаа явуулчихъя.

Нишүүд үг хэлж дууссан.

Санал хураалт явуулъя.

Би та бүхэндээ томъёололыг нь уншиж танилцуулъя.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ.

Санал хураалт.

Гишүүдийн 58.8 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулна.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний

тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үүгээр дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

14:36

Дууны бичлэгээс буулгасан:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА**